



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

"Олон улсын худалдаа логистикийн төв" ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2024/94/НА-СТА-ОНА

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК Захирал А.Сарангэрэл Утас: 99884842 Цахим хаяг: Gereltekhhburtgelaudit02@gmail.com Ахлах аудитор: Д.Галт-Эрдэнэ Утас: 80085430 Цахим хаяг: Gereltekhhburtgelaudit02@gmail.com Аудитор С.Дашдэндэв Утас: 80099418 Цахим хаяг: Gereltekhhburtgelaudit02@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.03.15 № 475

танай _____-ны № _____-т

ОЛОН УЛСЫН ХУДАЛДАА
ЛОГИСТИКИЙН
ТӨВ ХК-ИЙН ЗАХИРАЛ
С.МӨНХБАТ ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Олон улсын худалдаа логистикийн төв ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Олон улсын худалдаа логистикийн төв ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Олон улсын худалдаа, логистикийн төв" ХК нь 2023 онд 3387 автомашины зогсоолын түрээс, ашиглалт, хураамж, 139 зөөврийн сууцны ашиглалт, цахилгааны төлбөр, 1300 өмчлөлтэй зогсоолын газрын төлбөрөөс нийт 2,469.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 3,022.9 сая төгрөгийн зардал гарган ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл

үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 2 арга хэмжээ 30 хувийн гүйцэтгэлтэй, 13 арга хэрэгжээгүй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	60,596,398.34	60,636,254.66
1.1.2	Дансны авлага	433,820,747.61	480,270,947.69
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	104,531.47	104,531.47
1.1.6	Бараа материал	372,183,871.42	99,389,119.88
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	344,657,454.55	344,657,454.55
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	96,747,389.59	96,747,389.59
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,308,110,392.98	1,081,805,697.84
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	13,662,337,342.27	12,912,345,285.15
1.2.2	Биет бус хөрөнгө	46,528,608,000.00	46,528,608,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	60,190,945,342.27	59,440,953,285.15
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	61,499,055,735.25	60,522,758,982.99
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	1,374,589,014.63	893,567,899.56
2.1.1.3	Татварын өр	30,704,690.90	143,349,171.94
2.1.1.4	НДШ – ийн өглөг	402,302.61	10,042,342.72
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	14,956,327.76	21,958,131.11
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	191,994,000.05	186,441,275.05
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,612,646,335.95	1,255,358,820.38
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,612,646,335.95	1,255,358,820.38
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	29,521,070,796.00	29,521,070,796.00
2.3.2	хувийн	0.00	0.00
2.3.3	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	16,005,129.80	16,005,129.80
2.3.4	Эздийн өмчийн бусад хэсэг	33,288,739,667.00	33,288,739,667.00
2.3.5	Хуримтлагдсан ашиг	(2,939,406,193.50)	(3,558,415,430.19)
2.3.6	Эздийн өмчийн дүн	59,886,409,399.30	59,267,400,162.61
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	61,499,055,735.25	60,522,758,982.99

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,786,715,443.83	2,469,707,784.83
3	Нийт ашиг(алдагдал)	1,786,715,443.83	2,469,707,784.83
5	Хүүгийн орлого	0.00	269,238.37
9	Борлуулалт, маркетингийн зардал	897,089,678.99	1,310,712,000.12
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,313,153,276.30	1,703,596,432.01
12	Бусад зардал	14,867,409.08	8,636,738.09
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(143,622,255.53)	(66,041,089.67)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(582,017,176.07)	(619,009,236.69)
19	Орлогын татварын зардал	0.00	0.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(582,017,176.07)	(619,009,236.69)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(582,017,176.07)	(619,009,236.69)
24	Орлогын нийт дүн	(582,017,176.07)	(619,009,236.69)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	29,521,070,796.00	(2,373,895,866.87)	60,451,919,725.93
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	29,521,070,796.00	(2,373,895,866.87)	60,451,919,725.93
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	(582,017,176.07)	(582,017,176.07)
7	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	29,521,070,796.00	(2,939,406,193.50)	59,886,409,399.30
9	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	29,521,070,796.00	(2,939,406,193.50)	59,886,409,399.30
10	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	(619,009,236.69)	(619,009,236.69)
13	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	29,521,070,796.00	(3,558,415,430.19)	59,267,400,162.61

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,944,028,009.44	2,717,124,675.33
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,930,400,417.28	2,693,420,150.83
	Буцаан авсан албан татвар	13,627,592.16	23,704,524.50
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(1,846,390,254.87)	(2,612,103,697.83)
	Ажиллагчдад төлсөн	(571,591,490.98)	(745,414,950.75)
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(168,224,745.03)	(205,532,514.27)
	Бараа материал худалдан авахад төлсөн	(979,420,112.34)	(1,430,130,182.72)
	Ашиглалтын зардалд төлсөн	(1,243,000.00)	-
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(20,846,686.37)	(4,304,318.18)
	Татварын байгууллагад төлсөн	(48,922,137.56)	(164,271,664.36)
	Даатгалын төлбөрт төлсөн	(98,010.00)	(663,300.00)
	Бусад мөнгөн зарлага	(56,044,072.59)	(61,786,767.55)
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	97,637,754.57	105,020,977.50
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	269,238.37
	Хүлээн авсан хүүгийн орлого	-	269,238.37
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(62,794,781.82)	(105,250,359.55)
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(62,794,781.82)	(105,250,359.55)
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(62,794,781.82)	(104,981,121.18)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	34,842,972.75	39,856.32
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	25,753,425.59	60,596,398.34
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	60,596,398.34	60,636,254.66

"Олон улсын худалдаа логистикийн төв" ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	2023 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
A	Авто зогсоолын түрээс	1,126,409,530	1,998,000,000	1,594,497,931.54	(403,502,068.46)	79.80
	Контейнер байрлуулсаны орлого	37,563,636.18	36,000,000.00	14,036,363.55	21,963,636.45	38.99
	Авто зогсоол ашиглалтын орлого	30,111,910.00	144,000,000.00	151,936,235.88	7,936,235.88	105.51
	Өмчлөлтэй зогсоолын газрын төлбөр	10,817,790.00	-	24,523,194.5	24,523,194.50	100.00
	Сурталчилгааны самбарын түрээс	9,452,271.64	10,800,000.00	4,300,000.00	(6,500,000.00)	39.81
	Зөөврийн барилгын газар ашиглалт	239,405,630.09	185,948,400.00	264,833,991.25	78,885,591.25	142.42
	Цахилгаан орлого	176,549,430.29	118,332,000.00	170,857,672.05	52,525,672.05	144.39
	Орох хаалганы тасалбарын орлого	99,539,525.63	99,840,000.00	237,527,805.13	137,687,805.13	237.91
	Чанга яригч үзель	557,270.00	1,848,000.00	297,318.18	(1,550,681.82)	16.09
	Дугаартай автомашин болон цахимаар авто машин борлуулах	22,641,020.00	86,400,000.00	-	(86,400,000.00)	-
	Дугуй түржигчийн орлого	8,130,690.00	3,000,000.00	2,870,909.12	(129,090.88)	95.70
	Бусад түрээсийн орлого (АТМ, Киоск)	10,464,010.00	9,600,000.00	4,026,363.63	(5,573,636.37)	41.94
	Чирэгч машины орлого	1,800,000.00	1,800,000.00	-	(1,800,000.00)	-
	Авто машин түр журамлах хашаа	13,272,730.00	720,000.00	-	(720,000.00)	-
	Нийт орлогын дүн	1,786,715,444.00	2,696,288,400.00	2,469,707,785.00	(226,580,615.17)	91.60
	Цалин хөлс	717,613,100.00	967,824,000.00	921,241,833.83	46,582,166.17	95.19
	Нийгмийн даатгалын шимтгэл	89,353,900.00	120,978,000.00	112,249,892.55	8,728,107.45	92.79
	Албан татвар хураамж /Машины татвар бусад/	-	-	97,500.00	(97,500.00)	100.00
	Ашиглалтын зардал	247,457,324.37	285,400,000.00	273,315,222.72	12,084,777.28	95.77
	Бичиг хэргийн материал	5,551,800.00	7,980,600.00	15,445,658.98	7,465,058.98	193.54
	Хангамжийн материалын зардал	74,133,600.00	31,131,000.00	147,528,029.40	116,397,029.40	473.89
	Сургалтын зардал	3,680,000.00	6,584,000.00	5,190,000.00	1,394,000.00	78.83
	Түрээсийн зардал /байр, тоног төхөөрөмж/	-	-	31,250,000.00	(31,250,000.00)	100.00
	Тогтмол үйлчилгээ, засвар	35,240,550.00	43,500,000.00	103234630.92	59734630.92	237.32
	Шатахууны зардал	20,709,000.00	10,552,568.00	26,606,808.43	16,054,240.43	252.14
	Даатгалын зардал	-	-	663,300.00	(663,300.00)	100.00
	Утас, интернэт	4,403,100.00	9,696,000.00	5,643,102.44	4,052,897.56	58.20
	Томиллот /унаа, буудал, хоол/	-	5,000,000.00	-	5,000,000.00	-
	Элэгдлийн зардал	831,125,500.00	880,000,000.00	836,472,905.19	43,527,094.81	95.05
	Газрын төлбөр	132,203,100.00	99,168,450.00	160,097,871.00	60,929,421.00	161.44
	Банкны үйлчилгээний зардал	14,867,410.00	5,000,000.00	264,226,820.11	(259,226,820.11)	528.45
	Үйл ажиллагааны бус зардал	9,669,000.00	8,000,000.00	8,636,738.09	(636,738.09)	107.96
	Зар сурталчилгааны зардал	11,249,300.00	20,250,000.00	26,722,272.73	6,472,272.73	131.96
	Хөдөлмөр хамгааллын зардал	1,826,360.00	8,460,000.00	1,564,129.27	6,895,870.73	18.49
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал	22,677,320.00	9,700,000.00	80,605,454.55	(70,905,454.55)	830.98
	Сэлбэг хэрэгсэл	3,350,000.00	4,500,000.00	2,153,000.01	2,346,999.99	47.84
	Нийт зардлын дүн	2,225,110,364.37	2,523,724,618.00	3,022,945,170.22	(499,220,552.22)	119.78
	хүүгийн орлого	-	-	269,238.37	-	-
	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз(гарз)	(143,622,255.53)	-	(66,041,089.67)	(66,041,089.67)	100.00
	Нийт ашиг	(582,017,176.07)	172,563,782.00	(619,009,236.69)	(446,445,454.69)	358.71
	Цэвэр ашиг	(582,017,176.07)	155,307,403.80	(619,009,236.69)	(463,701,832.89)	398.57

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 4,429.3 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав.

Залруулсан алдаа:

- Худалдан авсан 4,429.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайлангийн үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний зардлаар тайлагнаж, хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээний зардалд бүртгэж, тайлагнаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 5.1.5 "хэмжигдэхүйц байх", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 19,997.1 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд 4 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа зөрчлөөс 16,692.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 47,374.6 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Илрүүлэлт-1: Тайлант онд 2 газрын дуудлага худалдааг зохион байгуулаагүй, Нийслэлийн ЗДТГ-ын төрийн санд өгөх өглөгийг барагдуулаагүй байна. Энэ нь Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 "тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлснийг үндэслэн газрыг аймаг, сум, нийслэлийн тусгай хэрэгцээнд авах, түүний хэмжээ, зааг, ашиглах журмыг тогтоох" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Газрын дуудлага худалдааг зохион байгуулах, өглөгийг барагдуулах.

Илрүүлэлт-2: Тайлант онд компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг хугацаанд нь хуралдуулахаар санал хүргүүлсэн боловч хуралдаагүй байна. Энэ нь компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 "Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн шийдвэрээр

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор зарлан хуралдуулна" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Компанийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажиллах, хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах.

Илрүүлэлт-3: Авлагын дансны эцсийн үлдэгдэлд 1 байгууллагатай холбоотой 16,692.1 мянган төгрөгийн он дамжсан авлага бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах,,," заалт, мөн хуулийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Он дамжсан хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах ажлын хэсэг томилон шат дараатай үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх, авлагыг барагдуулах.

Илрүүлэлт-4: Нийт 6 байгууллагатай холбоотой 3,305.0 мянган төгрөгийн худалдан авалтыг төлбөрийн И баримтаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2 "бараа ажил үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно", 17.6 "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авалт хийх тухай бүрд И баримтаар баталгаажуулж байх, татварын хууль тогтоомжийг мөрдөн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Худалдан авсан хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайланд тайлагнаагүй	1	4,429.3	-	-	1	4,429.3	1	4,429.3	-	-	-	-
Дүн	1	4,429.3	-	-	1	4,429.3	1	4,429.3	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд газрын дуудлага худалдааг зохион байгуулаагүй, Нийслэлийн ЗДТГ-ын төрийн санд өгөх өглөгийг барагдуулаагүй	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хугацаанд нь хуралдуулахаар санал хүргүүлсэн боловч хуралдаагүй	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Он дамжсан авлага бүртгэлтэй	1	16,692.1	-	-	-	-	1	16,692.1	-	-	-	-
Худалдан авалтыг төлбөрийн И баримтаар баталгаажуулаагүй	1	3,305.0	-	-	-	-	1	3,305.0	-	-	-	-
Дүн	4	19,997.1	-	-	-	-	4	19,997.1				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс		
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж

"Олон улсын худалдаа логистикийн төв" ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1	196,271.6	-	-	1	196,271.6	-	-
Дүн	1	196,271.6	-	-	1	196,271.6	-	-
Төрийн хэмнэлтийн хуультай холбоотой зөрчил								
Хөрөнгийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй олж бэлтгэсэн	1	11,426.2	-	-	1	11,426.2	-	-
Дүн	1	11,426.2	-	-	1	11,426.2	-	-
Нийт дүн	2	207,697.8	-	-	2	207,697.8	-	-